



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/70

Мандсаномь

Шүлхийн вакцинжуулалтыг зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, 4.5.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал, амьтны гоц халдварт "Шүлхий" өвчин гарсан эрсдэлтэй сумдын мэдрэмтгий малыг вакцинжуулах ажлыг 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Шүлхийн вакциныг хүлээж авах ажлын хэсгийг нэгдүгээр, вакцинжуулалтын хуваарийг хоёрдугаар, вакцинжуулалтанд хяналт тавих онцгой комиссын гишүүдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг АЗДТГазрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

0200225